ГОВЬСҮМБЭР АЙМАГ
# ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 08 сарын 29 өдөр Дугаар А/121 Шивээговь сум

## Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.2, 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2, Сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2023 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн “Сумын 2023 оны төсөвт нэмэлт өөрчлөлт оруулах тухай” 04 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.Сумын 2023 оны Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх “Төрийн албан хаагчдын орчин нөхцөлийг сайжруулах арга хэмжээний хүрээнд хийгдэж буй хурлын ширээ, сандал, шүүгээ, бичгийн ширээ худалдаж авах” ажилд 17,292,200 (арван долоон сая хоёр зуун ерөн хоёр мянга хоёр зуу) төгрөгийг зарцуулсугай.

2.“Төрийн албан хаагчдын орчин нөхцөлийг сайжруулах арга хэмжээний хүрээнд хийгдэж буй хурлын ширээ, сандал, шүүгээ, бичгийн ширээ худалдаж авах” ажилд 17,292,200 (арван долоон сая хоёр зуун ерөн хоёр мянга хоёр зуу) төгрөгийг Орон нутгийн хөгжлийн сангаас зохих хууль журмын дагуу анхан шатны баримт бичгийн бүрдлийг хангаан зарцуулахыг нягтлан бодогч (Л.Цэнд-Аюуш)-д зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Отгонжаргал)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА Ч.СУГАРМАА

42123 397